



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 05 сарын 06 өдөр

Дугаар А/340

Булган сум

**“Үндэсний бичиг соёл, номын өдрүүд 2026”
арга хэмжээний зардалд хөрөнгө гаргах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны IV хуралдааны аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны “Булганы сэргэлт хөтөлбөрийг батлах тухай” IV/25 дугаар тогтоол, 2025 оны XII хуралдааны “Булган аймгийн 2026 оны төсөв батлах тухай” XII/90 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2026 оны “Хөтөлбөр, төлөвлөгөө, арга хэмжээний зардал батлах тухай” А/97 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үндэсний нэгдмэл үнэт зүйлийг бэхжүүлэх, бүх нийтийн соёлын боловсролыг дээшлүүлэх, иргэдэд хүрэх соёл, урлагийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор “Үндэсний бичиг соёл, номын өдрүүд 2026” арга хэмжээг зохион байгуулсугай.

2. Арга хэмжээг зохион байгуулахад шаардагдах 3,290,000 (гурван сая хоёр зуун ерэн мянга) төгрөгийг хавсралтаар баталж, аймгийн Засаг даргын “Бүх нийтийн соёлын боловсрол олгох төлөвлөгөө”-ний зардлаас санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (Д.Эрдэнэбилэг)-д зөвшөөрсүгэй

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР



8326010458

Аймгийн Засаг даргын 2026 оны
05 дугаар сарын 06-ныг ний өдрийн
А/ЗНО дугаар захирамжийн хавсралт

“Үндэсний бичиг соёл, номын өдрүүд 2026”
арга хэмжээний төсөв

Д/д	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
“Үндэсний бичгээр хэн сайн бичих вэ” цахим бичвэрийн уралдаан					
1	Тэргүүн байр	ш	1	300,000	300,000
2	Дэд байр	ш	1	200,000	200,000
3	Гутгаар байр	ш	1	100,000	100,000
4	Өргөмжлөл	ш	3	40,000	120,000
Нийт				720,000	
“Үндэсний бичгээр хэн зөв бичих вэ” гар бичвэрийн уралдаан					
1	Тэргүүн байр	ш	1	300,000	300,000
2	Дэд байр	ш	1	200,000	200,000
3	Гутгаар байр	ш	1	100,000	100,000
4	Өргөмжлөл	ш	3	40,000	120,000
Нийт				720,000	
“Үндэсний уламжлалт тоглоом наадгай” танин мэдэхүйн тэмцээн					
1	Тэргүүн байр	ш	1	200,000	200,000
2	Дэд байр	ш	1	150,000	150,000
3	Гутгаар байр	ш	1	100,000	100,000
Нийт				450,000	
Зохиолч, уншигчдын уулзалт, уншигчдын бага хурал					
1	Зохиолчдын хөлс	ш	2	500,000	1,000,000
2	Зохиолчдын замын зардал	-	2	100,000	200,000
3	Тайз чимэглэл	-	-	200,000	200,000
Нийт				1,400,000	
Нийт дүн				3,290,000	

--o00o--